



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/38

Ховд

Нэмэлт төсвийн данснаас татан төвлөрүүлсэн
мөнгийг буцаан олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн сангийн татан төвлөрүүлэлтийн 100160051499 тоот дансанд 2020 оны жилийн эцэст татан төвлөрүүлсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын 236 902 176 төгрөг /хоёр зуун гучин зургаан сая есөн зуун хоёр мянга нэг зуун далан зургаан/-ийн Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын даргын тушаал, Байгаль орчин, аялал жуулчилалын сайдын тушаалаар эрх шилжсэн хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл болон аймгийн нөөцийн өвс тэжээлийн нэмэлт төсвийн үлдэгдлийг 100160051410 тоот дансанд буцаан олгосугай.

2. Дээрх байгуулагаас татан төвлөрүүлсэн 236 902 176 төгрөг /хоёр зуун гучин зургаан сая есөн зуун хоёр мянга нэг зуун далан зургаан/-ийг нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлсэн данснаас буцаан олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч /Ц.Давааням/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ